7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас



зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.


Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар эзэмшүүлэгч;
Өмнөговь аймгийн Ханбогд сум
Засаг даргын Тамгын газар 103 дугаар өрөө

Газар эзэмшигч: **Клинтек ХХК**
Газрын байршил: **Өмнөговь Ханбогд 3-р баг ЦДАШ трассын дагуу**
Газар эзэмшигчийн хаяг: **Улаанбаатар Сүхбаатар 1-хороо Олимпын гудамж Жи центр 51 тоот**
Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: **/5204143/**
Харилцах утас: **70110546**

Газар эзэмшигч **Клинтек ХХК** нь гэрээний нөхцөлийг Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим систем /www.egazar.gov.mn/-д цагт зөвшөөрч, баталгаажуулав.

Энэхүү гэрээний нэг хувийг хадгалав.



Хавсралт 6 БОНЕҮ-ний хуулбар



"КЛИНТЕК" ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

1021-09-30 № 13/4582

танай _____-ны № _____-Т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас ирүүлсэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "102 МВт салхин цахилгаан станц"-ын төсөлд "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Засгийн газрын "Журам батлах тухай" 2013 оны 374 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.


Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2022 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт... хуудастай

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



**ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСЭЛТ, БАРИМТ БИЧИГ
ХҮЛЭЭН АВАХ МАЯГТ**

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Клинтек" ХХК, /Регистрийн дугаар 5204143/, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, олипын гудамж, жи центр 51 тоот.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-95113310, 70110546


Төслийн нэр: "102 МВт Ханбогд салхин цахилгаан станц"

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон баг нутаг дэвсгэр

Баримт бичгийн нэр	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/	Тийм	+	2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1/31 дугаар албан бичиг
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл	Тийм	+	
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/	Тийм	+	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт	Үгүй	-	
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан	Тийм	+	"Эко трэнд" ХХК-д боловсруулсан.
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)	Тийм	+	
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт	Тийм	+	
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/	Тийм	+	
Тусгай тэмдэглэл: "102 МВт Ханбогд салхин цахилгаан станц" төсөлд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын "Аргачлал батлах тухай" 2014 оны А-117 дугаар тушаалын хавсралтын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай гэж үзлээ.			

Ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт, материалыг хянасан:

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ШИНЖЭЭЧ**

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ХУУДАС

2021 оны 09-р сарын 29

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2021/Е72

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: "Клинтек" ХХК, /Регистрийн дугаар 5204143/, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, олипын гудамж, жи центр 51 тоот.

Холбоо барих утас, И-мэйл хаяг: 976-95113310, 70110546

Төслийн нэр: "102 МВт Ханбогд салхин цахилгаан станц"

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон баг нутаг дэвсгэрт

Газрын нэгж талбарын цэг:


№	X	Y
1	42 46 44 .83	107 25 36 .12
2	42 47 34.01	107 24 56.22
3	42 51 28.20	107 24 54 .21
4	42 58 53.46	107 24 50.39
5	42 58 15.90	107 26 14 .95
6	42 51 27 .17	107 26 16.57
7	42 47 53 .67	107 26 18.76
8	42 47 24 .80	107 26 19.05

Нийт талбайн хэмжээ: 40000 м²


Орон нутгийн санал: Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг Даргын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 01/621 тоот санал, Е-Монголиа О99-2109-000022 дугаар хүсэлтийг тус тус үндэслэв.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт			Тийм	
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон			Тийм	

	нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)				
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх			Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
	Амьтны аймаг				
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ					



	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх	Тийм			
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	
Нэгдсэн дүгнэлт:					
Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "102 МВт Ханбогд салхин цахилгаан станц"-ын төсөлд хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
Онцгойлон анхаарах зүйлс:					
<ol style="list-style-type: none"> 1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам", байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулах. 2. 2012 оны 5 дугаар сард батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Байгаль орчны сайдын 2010 оны 156 дугаар тушаалаар батлагдсан "Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал"-ын дагуу төслийн үйл ажиллагаанаас ургамал, хөрс, ус, амьтан, агаар орчинд учруулах, учирсан хохирлыг байгалийн бүрэлдэл тус бүрээр тогтоож, улмаар тухайн газрыг эвдрэлд оруулснаар хохирлын хэмжээг урьдчилан тооцож нийлбэр үнэлгээ гарган төслийг цаашид хэрэгжүүлэх тохиолдолд байгаль орчны хариуцлагын болон эдийн засгийн үндэслэлийг тодорхойлж дүгнэлт гаргах; Түүнчлэн өмнөх суурь судалгаатай мэдээллийг харьцуулж дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах зүйлийг тодорхойлох; 3. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10¹ дүгээр зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг 2 жил тутамд төслийн үйл ажиллагаанд хийх асуудлыг холбогдох зардлын хамт тайланд тусгах; 4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийн хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах 					






5. Хөрсний элэгдэл, эвдрэлийн өнөөгийн байдлыг тодорхойлж, төслийн үйл ажиллагаанаас үүдэн бий болж болзошгүй сөрөг нөлөөлөл түүнээс сэргийлэх болон нөлөөллийг багасгах арга хэмжээ түүнд шаардагдах хөрөнгө зардлыг нарийвчлан тооцох;
6. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдал болон ашиглагдаж байгаа тоног төхөөрөмж, материалаас гарах тусгай ангиллын хог хаягдлыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулах, ангилан ялгах, дахин ашиглах, устгах, зайлуулах аргыг нарийвчлан тооцож, төслийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг болгон хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр устгах, зайлуулах талаар зөвлөмж боловсруулах, бүлэг болгон тайланд тусгах;
7. Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрсөнд үүсэх бохирдлыг нарийвчлан тооцож, түүнийг арилгах, бууруулах талаар зөвлөмж боловсруулж, байгаль орчны бохирдол багатай техник, технологийн сонголт хийх;
8. Төсөл хэрэгжиж буй газар нутагт амьдарч буй иргэд, сумын удирдлагуудтай хамтран ажиллах, төслийн үйл ажиллагааны цар хүрээ, байгаль орчинд халгүй аргаар нийгэм, эдийн засаг, орон нутгийн хөгжилд үзүүлэх давуу болон сул талыг дэлгэрэнгүй танилцуулж, тэдний саналыг албан ёсоор авах, БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах;
9. Төслийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын улмаас хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх зөвлөмж боловсруулах;
10. Төсөл хэрэгжиж буй газар нутгийн нөлөөллийн бүсийг тогтоож, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх болон байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээг тодорхойлон судалгаа хийж дүгнэлт боловсруулан гаргах;
11. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн цаг агаарын өөрчлөлтийг тодорхойлж түүнээс эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаанд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, түүнийг багасгах арилгах арга зам, шаардагдах хөрөнгө зардлыг тогтоох;
12. Холбогдох хуулинд нийцүүлэн эрх бүхий байгууллагаар баталгаажсан зураг төсөл, газар эзэмших эрхийн гэрчилгээ, Эрчим хүчний яамнаас олгогддог тусгай зөвшөөрөл болон холбогдох бичиг баримт, шинжилгээний дүн мэдээг тус тус тайланд хавсаргах;
13. Төслийн үйл ажиллагааны явцад унд ахуйд ашиглаж буй цэвэр усны хэрэглээний хэмжээг эх үүсвэртэй уялдуулан, түүнээс гарах ахуйн бохир усыг тус тус нарийвчилан тооцох, түүнчлэн хог хаягдлын менежментийн асуудлыг бүлэг болгон байгаль орчинд халгүйгээр зайлуулах аргыг нарийвчилан тодорхойлох
14. Төслийг холбогдох стандартын шаардлагыг хангуулах талаар дүгнэлт боловсруулж, тайланд хавсаргах;



Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурдсан арга хэмжээг цаг хугацаанд нь ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай" хуулийн дагуу хариуцлага тооцохыг урьдчилан мэдэгдье.

Бусад зүйлс:

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг цаг тухай бүрт нь ханган биелүүлж байх;
2. Байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөц баялгийг зохистой ашиглахтай холбогдсон хууль тогтоомжийг биелүүлэх талаар байгаль орчин, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай байнга хамтран ажиллах;
3. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
4. Ерөнхий үнэлгээнд заасан чиглэл, нөхцөл, болзлоос өөр үйл ажиллагаа явуулах болон төсөлд өөрчлөлт орох, эсхүл өргөтгөх, шинэ тоног төхөөрөмж, технологи нэвтрүүлэх бүрт Ерөнхий үнэлгээнд хамрагдаж байх;



<p>Ерөнхий үнэлгээ хийсэн:</p> <p>Албан тушаал: Байгаль орчин, аялал жуулчлалын яамны шинжээч</p> <p>Овог, нэр: Н.Эрдэнэчимэг</p> <p>Гарын үсэг: </p> <p>Огноо: 2021.09.29</p>	<p>Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:</p> <p>Албан тушаал: "Клинтэк" ХХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Овог, нэр: Ханс Кристоф Брумберг</p> <p>Гарын үсэг: </p> <p>Огноо: 2021.10.06</p>
---	--





МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2022.01.24 № 13/427

танай _____-ны № _____-т

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН
НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХИЙХ
ЭРХ БҮХИЙ МЭРГЭЖЛИЙН
БАЙГУУЛЛАГУУДАД

Хугацаа сунгах тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын зорилт, чиглэл, хамрах хүрээ, болон хугацааг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тодорхой заадаг болно.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах, халдвар хамгааллын дэглэм сахиулан ажиллаж байгаатай холбогдуулан баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлыг зохион байгуулах ажил удаашралтай байна.

Уг нөхцөл байдлыг харгалзан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан нарийвчилсан үнэлгээний тайлан ирүүлэх хугацааг нэг удаа сунгасан бөгөөд хугацааг дахин сунгуулах хүсэлтийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байна.


Иймд 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд тус яамнаас гаргасан бүхий л чиглэлийн төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан нарийвчилсан үнэлгээний тайлан ирүүлэх хугацааг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаагаар сунгаж байгааг үүгээр мэдэгдье.

Нарийвчилсан үнэлгээний тайланг дээрх хугацаанд ирүүлж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлүүлэх боломжтой.

Хувийг: Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх үүрэг хүлээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ



15227 -11

Хавсралт 7 Орон нутгийн хэлэлцүүлгийн материалын хуулбар



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА

48017 Өмнөговь аймаг, Ханбогд сум, Газлууд баг
И-мэйл: xanbogd.ZDT.G@gmail.com

2021.08.31 № 01/621
танай _____ -ны № _____ -г

БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД

Санал хүргүүлэх тухай

Клинтек ХХК нь 2008 оноос эхлэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын Номгон багийн нутагт үйл ажиллагаа явуулж, сэргээгдэх эрчим хүчний "Ханбогд Салхин Цахилгаан Станц" төсөл санаачлан, хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус компани нь манай аймаг, суманд үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойшхи он жилүүдэд орон нутгийн ард иргэд, засаг захиргаатай нягт хамтран ажиллаж иргэдийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, багийн малчдад хэд хэдэн худаг гарган өгсөн, галбын говийн эко системийг хамгаалж мод тарих, ургамалжуулах зэрэг ажлуудыг хийж Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөл, хөтөлбөрөө хэрэгжүүлж, ажлын хэрэгжилтийг орон нутгийн засаг захиргаа, нутгийн иргэдэд цаг тухайд нь мэдээллэж ирсэнд нутгийн иргэд болон Засаг даргын зүгээс талархалтай байдаг.

Уг төсөл нь байгаль экологид ээлтэй, дэлхийн дулаарлын эсрэг хийгдэж байгаа арга хэмжээ болж байгаа төдийгүй сум орон нутгийн зүгээс газар шороо, байгаль, дэлхийгээ хамгаалах бодлоготой бүрэн нийцэж байна.

Тиймээс бид эргэлзэх зүйлгүй "Ханбогд Салхин Цахилгаан Станц" төслийг сумын ард иргэд болон Засаг даргын зүгээс бүрэн дэмжж байгаа бөгөөд тус компаний Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.2, 7.3 -т заасны дагуу төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэх, төслийг хэрэгжүүлэхийг дэмжж байгааг маань хүлээн авна уу.

ЗАСАГ ДАРГА



X.НЭХИЙТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХАНБОГД СУМЫН НОМГОН БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 13/15

Ханбогд

Байгаль орчны нөлөөллийн
нарийвчилсан үнэлгээний тайланг
хэлэлцсэн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам”-ын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Багийн Иргэдийн Нийтийн Тэргүүлэгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжиж буй Ханбогдын салхин цахилгаан станцын төсөл болон уг төсөлд “Эко Трэнд” ХХК-ний хийсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнтэй танилцлаа. Ханбогд сумын Номгон багийн Иргэдийн Нийтийн Тэргүүлэгчдийн Хурлаас татгалзах зүйлгүй.
2. БОННҮ-ний үр дүнд үндэслэн боловсруулсан БОМТ-ний төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж, түүний хэрэгжилтийг нутгийн иргэд, нөлөөлөлд өртөгчдөд хяналт тавьж, олон нийтийн оролцоог ханган ажиллахыг багийн Засаг дарга У.Гантөмөрт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА *С. Баярмагнай* С.БАЯРМАГНАЙ



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН
НОМГОН БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 13/15

Модот хошуу

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Ханбогдын салхин цахилгаан станцын төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг танилцуулах

ХЭЛЭЛЦСЭН нь:

“Эко Трэнд” ХХК-ийн мэргэжилтэн Ц. Жанрайдөл, “Клинтек” ХХК-ийн Мөнхсолонго нар хурлыг эхлүүлж, хүн бүрт цаасан хэлбэрээр танилцах материал тарааж өглөө. Мөн танилцуулгыг танилцуулахаар бэлтгэл ажлыг хангав. Төсөл хэрэгжүүлэгч “Клинтек” ХХК-ийн мэргэжилтэн С. Мөнхсолонго нь төслийн танилцуулга, “Клинтек” ХХК-ийн ерөнхий мэдээлэл, төслийн байршил, салхин сэнсний ажиллагааны тухай мэдээлэл, салхин цахилгаан станцыг барих дараалал, барилгын ажлын урьдчилсан хуваарийн талаар мэдээлэл өгөв. Цааш “Эко Трэнд” ХХК-ийн мэргэжилтэн Ц. Жанрайдөл Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангаас танилцууллаа. Үүнд: Судалгааны хамрах хүрээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээний үйл явц, БОАЖЯ-аас хүлээн авсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ, “Эко Трэнд” ХХК болон “ERM” судалгааны байгууллагуудын товч мэдээлэл, байгаль орчин нийгмийн суурь судалгааны мэдээлэл цуглуулах ажил болон судалгааны үр дүнг танилцууллаа.

Судалгааны үр дүнд агаарын чанарын суурь үзүүлэлт сайн, дуу шуугианы түвшин Монгол улсын зөвшөөрөх хэмжээнээс доогуур байгаа гэсэн мэдээлэл өгөв. Харин газрын доорх усны хувьд 6 худгийн дээжээс 2-т нь “цахилгаан дамжуулах чанар” зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн байгааг онцлов. Хөрсөн бүрхэвчид хийсэн хэмжилтээр мөнгөн ус, хүнцэлийн агууламж стандартад заасан хэмжээнээс бага байсан байна. Ургамлын хээрийн судалгаагаар нийт 47 зүйлийн ургамал бүртгэгдсэнээс нэн ховор-5, ховор-2 ургамлыг бүртгэсэн байна. Сээр нуруугүйтэн эхний судалгаагаар 7 овогт хамаарах 8 төрөл, хоёр дахь судалгаагаар 6 овгийн 7 төрлийн сээр нуруугүйтэн бүртгэсэн бол шувууны судалгаагаар нийт 12 багийн 63 зүйлийн 4881 бодгаль нийт 9 сарын хугацаанд бүртгэгдсэн тухай мэдээлэл өглөө. Хөхтөн амьтдын судалгааг цахилгаан дамжуулах агаарын шугамаас 2 км, төслийн талбайгаас 10 км зайд хийж гүйцэтгэсэн байна. Мөн нийгэм эдийн засгийн суурь судалгааны үр дүн, судалгаанд хамрагдсан иргэдийн төслийн талаарх ойлголт, эерэг сөрөг нөлөөлөл, хүлээлт зэргийг танилцууллаа. Түүх соёлын өвтэй холбоотойгоор угсаатан зүй, археологи, палеонтологийн судалгааны үр дүнгийн талаар танилцуулга хийлээ. Оролцогч талуудтай хийсэн уулзалтуудыг танилцууллаа.

Төслийн холбогдолтой болзошгүй эерэг, сөрөг нөлөөллүүдийг танилцуулж, сөрөг нөлөөллүүдийг хэрхэн бууруулах арга замуудыг дурдав. Үүнд:

-Барилгын үе шатанд:

Газар шорооны ажлын дараа нөхөн сэргээлтийг хийх, хог хаягдлын менежмент, стратеги боловсруулж ажиллах, машин механизм, тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг тогтмол гүйцэтгэх, ховор ургамал, ан амыдад нөлөөлөл үзүүлэхээс зайлсхийх, тогтсон замуудад бага хурдтай зорчих, бага дуу шуугиантай машин механизм ашиглах, говийн бага ДЦГ-ын захиргаатай хамтран ажиллах, түүх соёлын өв дурсгал санамсаргүй байдлаар олдсон тохиолдолд авах арга хэмжээний талаар мэдлэгтэй болгох

-Үйл ажиллагааны үе шатанд:

Тогтоосон авто замын дагуу тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах, цахилгааныг дамжуулах агаарын шугамд шувуу үргээгч систем суурилуулах, нутгийн иргэдийг ажилд авах хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх, төсөлтэй холбоотой санал гомдол барагдуулах процессыг төсөл хэрэгжүүлэгч “Клинтек” ХХК-ийн мэргэжилтэн С. Мөнхсолонго танилцуулж, санал хүсэлтийг хүлээн авах хаяг, холбогдох мэргэжилтний мэдээллийг өгөв.

“Эко Трэнд” ХХК-ийн мэргэжилтэн Ц. Жанрайдөл Өмнөговь аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу халдвар хамгаалалтын дэглэм баримтлан Номгон багийн иргэдтэй хэсэгчлэн уулзаж, Ханбогдын салхин цахилгаан станцын төслийн БОННУ-ний тайланг танилцуулсан ба нийт 44 иргэн мэдээлэл авсан тухай мэдээлэл өгөв. Иргэдийн хувьд уг төслийн талаар мэдээлэлтэй байна. Иргэдээс ирсэн асуултуудаас дараах асуултуудыг онцлон хэлэв. Үүнд:

Төслөөс бий болох цахилгааныг ямар хүмүүс хэрэглэх вэ? Зөвхөн Ханбогд сумын иргэд хэрэглэх үү? Төв замаас төслийн талбай хүрэх 3 км сайжруулсан замд малын гарам хийх үү? Сэнсний доор өргөст тор байх уу? Мал, амьтан өргөст торонд гэмтэх аюултай байдаг. Төслөөс иргэдэд ирэх давуу тал юу байгаа вэ?

Эдгээр асуултуудад зохих хариултуудыг өгсөн бөгөөд иргэдийн хувьд төслийн эерэг, сөрөг нөлөөллийн талаар мэдээллийг авч төслийн үйл ажиллагааг суманд хэрэгтэй гэж үзэж буйгаа илэрхийлсэн тухай танилцууллаа.

АСУУЛТ ХАРИУЛТЫН ХЭСЭГ:

Асуулт - Номгон багийн иргэд салхин сэнсний ажиллагааны талаарх ямар мэдлэгтэй байна вэ?

Хариулт-Жанрайдөл: Малчдын хувьд БНХАУ-ын нутаг дэвсгэр дээр байрлах салхин сэнснүүдийг харж байсан мөн Цогтцэций суманд байрлах салхин сэнсийг олон удаа харж байсан учир салхин сэнсний талаар тодорхой ойлголттой болсон байна.

Асуулт - Төслийн ажлын багт нутгийн иргэдээс илүүтэй хамрагдуулах боломжтой юу?


Хариулт - Мөнхсолонго: Төсөл хэрэгжих үед шаардагдах ажлын байранд бид нутгийн иргэдэд нээлттэй хамрагдах боломж олгоход анхаарч ажиллана. Мэдээж ажил мэргэжлээс хамаарч тавигдах шалгуур үзүүлэлтүүд байна.

Санал - ИНХ-ын дарга С.Баярмагнай: Номгон багийн иргэд төслийн талаар болон төслийн БОННУ-ний тайлангийн талаар бүрэн мэдээлэл авсан, ойлголттой байгааг харлаа. Иргэдээс ирүүлсэн санал, асуултуудтай танилцлаа. Уг төсөлтэй холбоотой татгалзах зүйлгүй байхгүй.

Санал - Номгон багийн Засаг дарга У.Гантөмөр: Номгон багийн Иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгчдээс болон багийн даргын хувьд татгалзах зүйлгүй.

Тэмдэглэл хөтөлсөн:

“Эко Трэнд” ХХК-ийн мэргэжилтэн



Н.Ишханд

Хянасан:

ИНХ-ын дарга



С.Баярмагнай



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ХАНБОГД СУМЫН ЖАВХЛАНТ БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 3/01

Ханбогд сум

**Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан
үнэлгээний тайланг хэлэлцсэн тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 23.1.6 дэх заалт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус үндэслэн багийн иргэдийн нийтийн хурлаас ТОГТООХ нь:

1. Клинтек ХХК-ийн хэрэгжүүлж буй Ханбогд салхин цахилгаан станцын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн үр дүнг иргэдэд хэлэлцүүлж дэмжсэнийг баталсугай.
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу "Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллүүдийг арилгах, бууруулахад энхаарч, иргэдээс гаргасан саналуудыг харгалзан үзэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч Клинтек ХХК-д үүрэг болгосугай."

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ



Н.ШИРНЭН

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байгуулах “102 МВт Ханбогд салхин цахилгаан станц” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний танилцуулга

2022 оны 09 сарын 26-ны өдрийн 15.40 цаг

Хурлыг Жавхлантаг багийн засаг дарга Жамбалсанжид нээж үг хэлэв. Иргэдийн хурлын дарга Ширнэн хурлын дэгийг танилцуулснаар хурлыг эхлэв.

Ханбогд салхин цахилгаан станцын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Экотрэнд ХХК-ийн байгаль орчны зөвлөх Энхтулга танилцуулав.

Асуулт 1. Малчин Ө.Баттогтох: Байгаль орчин нөлөөллийн байдлын үнэлгээг ямар компаниар хийлгэсэн бэ? Нөхөн сэргээлтэд мөнгө тавигдсан үү? Тайланд гарч байгаагаар нөхөн сэргээлтийн мөнгийг тусад нь тавиагүй байна, энэ нь буцаад хэцүү байдлыг үүсгэдэг. Компаниуд сайхан юм яриад л ажлаа бүтээгээд хаяад явчихдаг. Малчид бидний зүгээс газар нутгаа сэргээж, буцаагаад хэвийн байдалд оруулахыг л хүсдэг. Манай нутгийн хувьд үүл уурхайд нухлуулсан халширсан.

Хариулт. Энхтулга: Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг Экотрэнд ХХК хийсэн. Нөхөн сэргээлтийн төсвийг барилгын үйл ажиллагааны зардал болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан.

Асуулт 2. Малчин Эрдэнэбаяр: Сэнс барих газрыг аль багт хамаарах вэ? Багийн заагийн тухай хэлж өгвөл сайна байна. Сэнс барих газрын ердөө 3 км нь Номгон багийнх, бусад нь манай багийн газар нутаг гэж бодож байна. Бид нарт яг газар нутгийн нэрээр газрын нэршилийг хэлээд тайлбарлаж өгнө үү? Жавхлантаг багийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх цахилгаан дамжуулах агаарын шугамын 57.4 км-ийн зургаа сайн тайлбарлаж өгнө үү?

Хариулт. Энхтулга: Тухайн газар нутгийн нэр нь Замт гэдэг газар. Зурагт тусгаж тайлбарлаж өгсөн.

Хариулт. Клинтек ХХК, Төмөрбат: Салхин цахилгаан станц нь Оюутолгой уурхайн өмнөд кэмпийн зүүн талд баригдаж, цахилгаан дамжуулах агаарын шугам нь хойшоогоо Оюутолгой дэд станцад холбогдоно.

Асуулт 3. Малчин Эрдэнэбаяр: 12 км.кв талбай дээр 24 ширхэг сэнс барина гэсэн. 2009 онд 60 мянган га газар гэж яригдаж байсныг бодоход багасаад 12 км.кв болсныг сонсоход таатай байна. Гэхдээ 12 км.кв газар нутгийн хувьд олон малын бэлчээр, малчдын бүүж сүүх нутаг болно. Энэ тухайд юу гэж тайлбарлах вэ?

Хариулт. Энхтулга: Энд хашаалахгүй, мал бэлчдэгээрээ бэлчинэ. Барилгын ажил явагдах хэсгүүдийг аюулгүй байдлын үүднээс түр хашна.

Хариулт. Клинтек ХХК, Төмөрбат: Манай компаний барих гэж байгаа салхин станц нь 102 мвт цахилгаан үйлдвэрлэнэ, Цогтцэцийн станцаас өндөр хүчин чадалтай. Салхин сэнсийг хашаалахгүй учир малчид зэрэгцээд малаа маллаад тариа ногоогоо тариалаад явах боломжтой.

Асуулт 4. Дэндэвсамба: Төсөл хэрэгжүүлэгч болон байгаль орчны үнэлгээний тайлан боловсруулагч компани хоёрыг ялгаж салгамаар байна. Одоо энэ хурлаар зөвхөн 56.4 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугамын талаар арилцана гэж ойлгож байна. Трассын дагуу археологи хийсэн үү? Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн зардал орсон үү?



Хариулт Энхтүлгэ: Төсөл хэрэгжүүлэгч археологийн судалгааг хийлгэсэн. Нөхөн сэргээлтийн зардлыг барилгын үйл ажиллагааны зардалд тусгасан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан.

Асуулт 5. Малчин Цагаан: Цахилгааны шугамыг тавихыг дэмжихгүй байна. Олон зам харгуй малчдын амьдралд багадаагүй. Төмөр зам, трассын зам, хатуу хучилттай зам, сайжруулсан зах гээд байгаа малчдын амьдралд сөртөөр нөлөөлж байна. Хавар намрын улиралд тоос шороо босоод хэцүү байдаг. Энэ төсөл яг ямар үр ашигтай болоод үүнийг хэрэгжүүлэх гээд байна вэ? Малчид сайн бодож хэлэлцэж саналаа хэлэх хэрэгтэй байх шүү.

Асуулт 6. Малчин Долгормаа: Салхин сэнс малчдад ямар өгөөжтэй вэ? Өмнөх хохирол бид нарт зөндөө байна. Зам тавьж нүх ухаад нөхөн сэргээлт хийхгүй орхидог. Ухсан нүхэнд мал унаж үхэж байна.

Хариулт Клинтек ХХК, Төмөрбат: Улсын эрчим хүчний салбар ачаалал өндөртэй байгаа. Хүлэмжийн хийн ялгарал бүүрч, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөхүйц агаарын бохирдол бүүрнэ гэх мэтээр бидэнд болон улс оронд үр ашигтай.

Асуулт 7. Малчин Сүрэнхорол: 57.4 км агаарын шугамын ажлыг хийхийн тулд нүх ухах байх. Компаниуд нүхээ ухаад торон хашаа татахгүй орхисноос мал унаж үхдэг. Компани хамгаалалтаа сайн хийгээгүйгээс мал нүхэнд орж үхэх гэх мэтээр хохирол учирвал малчдад ямар нөхөн төлбөр баталгаа өгөх вэ гэдгээ тодруулах хэрэгтэй. Ухсан нүхийг хэн хариуцаж, хэрхэн яаж эргэх холбоотой байх, ямар амлалт өгөх вэ гэх мэтийг тодруулж өгчө үү?

Хариулт Энхтүлгэ: Таны ярьсан эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээг осол аваарын менежментийн төлөвлөгөөнд тусгасан. Төсөл хэрэгжүүлэгч жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж биелэлтийг хянуулна.

Хариулт Клинтек ХХК, Төмөрбат: Нарийвчилсан үнэлгээг хийсэн байгаль орчны үнэлгээний зөвлөх компанийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжийн дагуу ажиллана. Иймд агаарын шугамыг малчдад аль болох төвөг учруулахгүй, сөрөг нөлөө бага байхаар тооцож одоо байгаа хатуу хучилттай зам нь дагуу байхаар тооцож төлөвлөөд явж байна. Манай компанийн зүгээс гомдол барагдуулах механизм аар дамжуулж малчдын санал гомдлыг хүлээн авна.

Асуулт 8. Малчин Шинээ: Цахилгааны Оюутолгойд нийлүүлэхүү? Барьж дуусаад улсад хүлээлгэж өгөхүү? Ашгийг ямар компани авах вэ?

Хариулт Клинтек ХХК, Төмөрбат: Цахилгааныг Оюутолгой дэд станцад буюу улсад нийлүүлнэ. Энэ нь Оюутолгой ХХК-ийн дэд станц биш, станц бүр өөрийн нэр байдаг бөгөөд Оюутолгойн хажууд учраас ийм нэртэй байгаа юм. Өөрөөр хэлбэл төвийн эрчим хүчний системд цахилгаанаа нийлүүлнэ гэсэн үг. Энэ төслийг хэрэгжүүлснээр Хятад улс руу урсаж мөнгөн урсгалыг Монгол улсдаа үлдээх авах боломжтой юм. Ашгийг үйлдвэрлэсэн эрчим хүчийг тээвэрлэж төвийн системд нийлүүлж байгаа Клинтек компани авна. Төслийн санхүүжилтийг Германы WPD компани хийж байгаа юм.

Санал 9. Дэндэвсамба: Эрчим хүчийг өртөггүйгээр байгалийн нөөцийг ашиглаад үйлдвэрлэх нь улсад ашигтай. Малчид ч гэсэн мал аж ахуйн төсөл хэрэгжүүлж байгаа. Гол нь орон нутагт байгаа олон төслүүд үялдаа холбоогүй байгаад байна. Жишээдбэл Цагаансуваргын цахилгаан дамжуулах шугамын дагуу нүх ухаад шонгоо суулгаагүй орхисноос болж мал орж үхээд байгаа учир малчид



дүргүйцэж байна. Менежментийн төлөвлөгөөг жил бүр хэлэлцдэг учир малчид ч хянах боломжтой, мэдээллийг сайн өгөх хэрэгтэй.

Асуулт 10. Ширнэн, Төсөл байрлах газрын нэрийг тодорхой болгох хэрэгтэй, малчдаас асууж газар нутагийг орон нутгийн наршлээр хэлэх боломж байна.

Хариулт Клинтэк ХХК, Төмөрбат: Гомдол барагдуулах механизмыг компани олон улсын стандартын дагуу боловсруулсан. Багийн даргад энэ системийг хэрэгжүүлэх заавар зэргийг үлдээнэ. Та бүхэн танилцаарай.

Асуулт 11. Малчин Сүрэнхорол: 3.6 км зам хатуу хучилттай зам гэсэн, энэ нь төв кэмп рүү явах зам юм уу? 24 сэнс рүү очих 24 зам гарна байх, үүнтэй холбоотой үхсан нүхний асуудал гарна. Тэгхээр мал эндсэн тохиолдолд малчид компани хамтарсан хариуцлагын гэрээг эхнээс нь байгуулж болохгүй юу?

Хариулт Клинтэк ХХК, Төмөрбат: 3.6 км зам нь төслийн талбай руу явах зам. 24 сэнсний тухайд төслийн талбай дотор салхин сэнсний засвар үйлчилгээг хийх 24 км дотоод зам барина.

Багийн дарга Жамбалсачжид: Нийгмийн хариуцлагын хүрээнд компани орон нутагт хийхээр төлөвлөсөн зүйлс байна уу?

Хариулт Клинтэк ХХК, Төмөрбат: Одоогоор шууд хэлж чадахгүй байна. Та бүхэн гомдол, санал хүлээн авах механизмар дамжуулан саналаа хэлбэл бид хамтарч ажиллахад бэлэн.

Малчин

Хөгжлийн тал дээр хамтран ажиллаж болохуу? Олон замаа яаж нөхөн сэргээх вэ? Трассын дагууд ажиллахдаа малчидтай хамтрах хэрэгтэй. Малчид бид нар тэр шугамаас тог авч болохуу?

Хариулт Клинтэк ХХК, Төмөрбат: Болноо. Та бүхэн саналаа хэлбэл бид санал гомдол барагдуулах механизмаар дамжуулан хэрэгжүүлэх боломж байгаа. Харин тог авах тухайд орон нутаг эрчим хүчний эх үүсвэрийг ойртумдад ирчихсэн учир түүнийг ашиглах боломж ойртож байна гэж үзэж байна.

Тэмдэглэл хөтөлсөн :

Хянасан



Т.Сүмжидмаа

Н.Ширнэн

Хавсралт 8 Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн хуулбар



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

УСНЫ ГАЗАР

Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050
Утас/Факс: (976-51) 26 55 78,
Цахим шуудан: office@water.gov.mn,
Цахим хуудас: www.water.mn

2022.05.13 № 04/552


танай 2022.04.21-ны № 0421/01 -т

“ЭКО ТРЭНД” ХХК-Д

“Усны тухай” хуулийн 16¹.4.10 дахь заалтыг үндэслэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт “Клинтек” компанийн байгуулах “102 МВт Ханбогд салхин цахилгаан станц” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох бусад материалыг судлан үзээд усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

УСНЫ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Т.БОЛДБААТАР



УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

2022 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар-129

Улаанбаатар
хот

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

"Клинтек" ХХК, улсын бүртгэлийн дугаар: 9011138122, регистрийн дугаар: 5204143, холбоо барих утасны дугаар: 70110546, 95113310

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

"Эко трэнд" ХХК, холбоо барих утасны дугаар: 95958006

3. Төслийн нэр, байршил:

102 МВт Ханбогд салхин цахилгаан станц төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт хэрэгжих бөгөөд Галба-Өөш-Долоодын сав газарт хамаарна.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Төсөл хэрэгжүүлэгч компани нь эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийг (№28/2008) Эрчим хүчний зохицуулах хорооноос 2008 онд авсан ба 2020 онд сунгуулсан.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

24 ширхэг Vestas V-150 маркийн салхин турбиныг (тус бүр 4.3МВт чадал бүхий) суурилуулна. Салхин турбины гол баганын өндөр 105 м, нийт хүчин чадал нь 102МВт байх бөгөөд төслөөр нэвтрэх зам, дотоод зам, краны платформ, салхин цахилгаан үүсгүүрийн суурь, Галба дэд станц, хяналтын байрыг барьж барина. Барилгын ажлын үе шат нь нийт 14 сар үргэлжлэх (300 хоног) ба нийт 350 ажилтантайгаар ажиллана. Ашиглалтын үе шатанд нийт 20 ажилтан ажиллана.

6. Усны эх үүсвэр, байршил:

Төслийн усны хэрэглээг Ханбогд сумын Зүүн замтын кемп орчимд гаргасан өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана. Худгийн ундарга 2.0 л/сек, байршил 107° 27' 14.7", 42° 48' 59.6".

7. Ашиглах усны хэмжээ:

Төслийн усны хэрэглээг БОНХАЖ-ын Сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-оор тооцоход:

Төслийн барилгын ажлын үе шатанд (нийт 14 сар буюу 300 хоног):

Унд ахуйн усны хэрэглээ:

$$350 \text{ хүн} \times 80 \text{ л/хон} = 28.0 \text{ м}^3/\text{хон}$$

Технологийн ус хэрэглээ:

Салхин цахилгаан үүсгүүрийн суурийн бетон зуурмагийн ус хэрэглээ:

$$14,400.0 \text{ м}^3 \times 0.3 \text{ м}^3 = 4,320.0 \text{ м}^3/\text{жил}$$


Замын суурийн ус хэрэглээ (дотоод болон гадаад зам):

$$58,591.0 \text{ м}^3 \times 0.08 \text{ м}^3 = 4,687.3 \text{ м}^3/\text{жил}$$

Тоосжилт дарах усны хэрэглээ (дотоод болон гадаад зам):

$$117,183.0 \text{ м}^2 \times 2 \text{ л} = 43.7 \text{ м}^3/\text{хон} \text{ (жилд услах хоногийн тоо 56)} = 13,124.5 \text{ м}^3/\text{жил}$$

Барилгын ажлын үе шатанд нийт усны хэрэглээ **101.7 м³/хон буюу 30,510.0 м³/жил.**



Төслийн ашиглалтын үе шатанд (жилд 365 хоног):

Унд ахуйн усны хэрэглээ:

$20 \text{ хүн} \times 80 \text{ л/хон} = 1.6 \text{ м}^3/\text{хон}$ буюу $584.0 \text{ м}^3/\text{жил}$

Төслийн ашиглалтын үе шатанд нийт усны хэрэглээ $1.6 \text{ м}^3/\text{хон}$ буюу $584.0 \text{ м}^3/\text{жил}$.

8. Дүгнэлт:

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах (хамгийн өндөр ус хэрэглээтэй барилгын ажлын үе шатаар тооцож үзэхэд) $30,510.0 \text{ м}^3/\text{жил}$ ($101.7 \text{ м}^3/\text{хон}$) усны хэрэглээг 2 л/сек ($172.8 \text{ м}^3/\text{хон}$) ундаргатай гүний худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.


9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

Төслийг хэрэгжүүлэхдээ Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.3, 30.1.4, 30.1.5, 30.2.2 дэх заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллахыг "Клинтек" ХХК-д зөвлөж байна.

УСНЫ НӨӨЦИЙН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.Мөнгөнтуул

Б.МӨНГӨНТУУЛ



2022-12-02

Нийслэлийн тойргийн нотариатч

С.Гэрэл Бягдэлхуулийн

үзэн зөвийг гэрчилэв.

Нотариатч

Хавсралт 9 Техникийн тэмдэглэл. Болор ус компанийн 2022 оны 01 сарын 19-ний өдрийн хувилбар 2.0.



БОЛОР УС ХХК

102 МВт Ханбогд Салхин Цахилгаан Станцын газрын доорхи усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл

ТЕХНИКИЙН ДҮГНЭЛТ

Contents

1) Ерөнхий байдал.....	2
2) Судалгааны ажил.....	2
3) Одоо байгаа худгуудын хүчин чадал.....	4
4) Салхин станцын усны хэрэгцээ, шаардлага.....	5
5) Шинээр гаргах худгууд.....	6

Баримт бичигт гарын үсэг зурах хүснэгт

Компани	Үүрэг	Нэр	Гарийн үсэг	Тамга
Захиалагч	Төслийн техникийн менежер	Р. Рос		
Гүйцэтгэгч	Захирал	Л. Өлзийжаргал		
Гүйцэтгэгч	Гидрогеологич	Д. Хэнмэдхэв		

Баримт бичгийн засварын түүх

Хувилбар №	Гүйцэтгэсэн	Өөрчилсөн огноо	Тайлбар
0.0	Болор Ус ХХК	16-12-2021	Анхны хувилбар
1.0	Болор Ус ХХК	23-12-2021	word саналын дагуу шинэчилсэн хувилбар
2.0	Болор Ус ХХК	19-01-2022	ERM саналын дагуу шинэчилсэн хувилбар



102 МВт Ханбогд Салхин Цахилгаан Станцын газрын доорхи усны нөөцөд нөлөөлөх нөлөөлөл

Болор Ус ХХК -ийн техникийн тэмдэглэл, 2021 оны 12-р сарын 23

1) Ерөнхий байдал

Салхин станц барих газар нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс урагш 75 км-т Оюутолгойн хилийн боомт хүрэх замын ойролцоо, хилийн боомтоос хойш 35 км-т оршдог. Монголын говь нутаг нь хүн ам цөөн тархай суурьшсан дэд бүтэц, зам харгүй муу боловч нүүрс, зэсийн нөөц их Тавантолгой, Оюутолгой зэрэг уурхай, ордтой тул улсын экспортын чухал бүсэд тооцогддог. “2010 он Дэлхийн Банкаас /А. Түинхоф ба Буянхишиг/ хийсэн Зүүн өмнөд Говийн газрын дорхи усны үнэлгээ” –д зааснаар говийн усны нөөц нь цор ганц газрын гүний ус бөгөөд эргэн нөхөгдөх чадвар тун хомс гэж заасан байдаг. Газрын дорхи усны тэжээх эх булаг нь хур борооны ус байдаг гэвч говьд жилийн дундаж хур тундас дөнгөж 115-150 мм тул газрын дорхи усны нөхөн сэргэх хурд маш бага буюу дунджаар жилд 1 мм гэж тооцдог¹. Нөхөн сэргээх хурын ус нь газрын дорхи усны гүехэн буюу 20 м хүртэл уст үеийн дээд давхаргуудад эргэлдэх ба багаахан хэсэг нь доод үе 50 м ба түүнээс гүн давхаргын усыг нөхдөг гэж үздэг. Үүнээс үзэхэд хэрэв газрын дорхи усны нөөцөд нөлөөлж буй бол худгийн ялангуяа гүехэн худагт их нөлөөтэй ба худгийн түвшин мэдэгдэхүйц буурна.

2) Судалгааны ажил

Болор ус ХХК 2021 оны 10-р сарын 3-наас 10-р сарын 6-ны хооронд төслийн талбайд усны судалгаа хийсэн. 1990 оноос өмнө тус газарт аймгийн Усны Аж Ахуйг Удирдах Газар (УААУГ)-аас малчдын ус хангамжид зориулж Замт буюу Хаягдсан цооног (№1), Цувираа 3 гүний худаг (№2), Баруун Замт (№3), Цагаан чулуут 2 гүехэн (№4) худгууд гаргасан (Хүснэгт 1). Эдгээр худгийг 3-5 квт чадалтай бага оврын бензин генератор, 1,0-2,0 квт –н насосоор тоноглон байдаг. Энэ худгууд нь цагт 3-4 м³ ус гаргах чадалтай тул малчдын малын тоо, төрлөөс хамаарч хоногт 1-10 цаг ажиллаж 5-30 м³ ус ашиглаж байдаг. Тухайн нутаг нь монголын хамгийн олон тэмээтэй нутаг бөгөөд малчдын олонхи нь ус их уудаг тэмээн сүрэг хариулдаг. Судалгаагаар төслийн ойр хавийн талбайд нийт 13 инженерийн хийцтэй худаг байна.

¹ А. Түинхоф ба Н. Буянхишиг, 2010. Зүүн өмнөд Говийн газрын дорхи усны үнэлгээ. Монголын хэлэлцүүлгийн баримтууд, Ази Номхон Далайн Тогтвортой Хөгжлийн Газар. Вашингтон, ДС: Дэлхийн банк.



Тухайн бүсэд газрын дорхи усны нөөцийн судалгаа хийгдээгүй бөгөөд зөвхөн малчдын хэрэгцээнд ашиглаж ирсэн байна. Харин ОТ-н үүрхайд зориулж 2005 болон 2010 онуудад ОТ хавийн газруудад усны нөөцийн хайгуул хийсэн. Энэ хайгуулын ажлаар Гүний хоолой, Ундайн гол, Галба гэсэн 3 талбайд их гүний /300 м-с их/ усны нөөц олж тогтоосон. Энэ хайгуулаар төслийн талбай хавьд нийт 5 цооног ухснаас №5 ОТ10 цооногийг л автозамын тоос шороог дарахад ашиглах болж бусад №6, №7, №8, №9 нийт 4 цооногийг сумын захиргааны мэдэлд шилжүүлж өгсөн.

Клинтек (№10), Хөх дэрс (№11), Ар ус (№12), Мэнгэ (№13) худгийг малчдын хүсэлтээр хувийн хэвшлийнхэн өрөмдсөн ба малчид усыг зарж мөн өөрийн хэрэгцээнд ашигладаг. Тиймээс дээрх худгууд нь малчдын эзэмшилд байдаг.

Гашуун сухайтын хилийн боомт нь байнгын ажиллагаатай болж суурин байгуулагдсан боловч ойр хавьд нь үндны усны эх булаг байхгүй тул автозамын дагуу төслийн талбай дах худгуудаас сүүлийн 20 орчим жил ус зөөж хэрэглэдэг болоод байна. Нутгийнхан хилийн боомтын хэрэгцээнд зориулж эдгээр цооногт барилга барьж хамгаалан том хүчин чадлын мотор, насосоор тоноглон усаа зарж байгаа. Хилийн боомтын үйл ажиллагаа өргөжихийн хамт зам, барилга байгууламжийн барилгын усны хэрэгцээ шаардлага ихэсч байна. Гэсэн хэдий ч цар тахлын хязгаарлалтын улмаас хилийн бүс дэх бүх үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа хаагдсан тул усны хэрэглээ ердийн өдрийн хэрэглээнээс хамаагүй бага байв. Одоогийн усны хэрэглээг худаг өмчлөгчдөөс асуумж авсаны дагуу тогтоосон болно. (Хүснэгт 1-ийг харна уу).



Зураг №1. Зам, барилгын ажилд ус авахаар дараалалд зогссон автоцистернүүд

Болор ус ХХК, 15-4-29-р байр. 3р баг,
Даланзадгад хот, Өмнөговь аймаг



Хүснэгт 1: Төслийн талбайн ойролцоох худгууд

№	Худгийн нэр	Солбицол X	Солбицол Y	Ухаж гаргасан он	Гүн	Гаргасан компани	Өдрийн дундаж ашиглалт	Тухайн үеийн ашиглалт ¹
[-]	[-]	[WGS84 UTM]	[WGS84 UTM]	[-]	М	[-]	[м ³ /өдөр]	[м ³ /өдөр]
1	Замт (хаягдсан)	699662.31	4741951.18	1976	78	УААУГ	0	0
2	Цувираа	709217.85	4747580.37	1976	89	УААУГ	100	20 ²
3	Баруун замт	693242.46	4737696.60	1976	12	УААУГ	60	0 ²
4	Цагаан чулуут	692198.84	4734510.64	1976	9	УААУГ	50	40 ²
5	Т 10-р худаг	696594.31	4739421.36	2005	200	Т	300	100 ³
6	Буланцагаан	705011.20	4741976.06	2005	300	Т	250	20 ²
7	Эрдэнэ баяр	693160.88	4739164.01	2005	250	Т	200	20 ²
8	Шинэ худаг	694930.38	4737569.58	2005	180	Т	250	0 ³
9	Т цооног	696700.46	4735490.76	2005	200	Т	250	0 ³
10	Клинтек	700621.48	4743366.72	2014	62	Их ертөнц	120	0
11	Хөх дэрс	711084.01	4740587.72	2014	60	УААУГ	60	0
12	Ар ус	696967.66	4743090.55	2018	27	Болор Ус	80	0
13	Мэнгээ худаг	694350.47	4741627.85	2019	80	Цэнгэлжаргал	160	0 ³
Total							1880	200

¹ Санал асуулгаар тооцоолсон (утасны дуудлага, нүүр тулсан үүлзэл)

² Малын усалгаа болон хилийн гаалийн өртөөнд

³ Зөвхөн хилийн гаалийн өртөөнд зориулагдсан

3) Одоо байгаа худгуудын хүчин чадал

Төслийн талбай дахь ОТ-н цооногуудын мэдээлэл байхгүй тул малчид, эзэмшигчдийн өгсөн мэдээллийг үндэслэн гүн, ундарга, усны түвшинг тодорхойлсон болно. Малчид хоногт 5-30 м³ ус авч гэр ахуй, малын усан хангамж болон мод, ногоо тариалж байдаг. Ханбогд сум нь улсын хамгийн олон тэмээтэй нутаг бөгөөд 300-800 тэмээтэй малчин зөвхөн малын усанд хоногт 15-30 м³ ус хэрэглэдэг. Гэвч 2005-2010 оны үеэс хилийн боомтоор нүүрс, зэсийн баяжмалын экспорт ихэссэн тул автозам, төмөр зам барих болон ачих буулгах мэт бүтээн байгуулалтын ажилд ус ихээр шаардагдах болсон.

Энэхүү судалгаагаар нийт усны хэрэглээ усны нөөцөд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох юм. Судалгаа хийх үед дээрх худгуудаас хоногт дунджаар нийт 200 м³ ус зөөж байсан ба энэ нь нэгд, барилгын улирал дуусч байгаа, хоёрт, малчдын олонхи нь өвөлжөө рүү нүүсэн тул усны хэрэглээ бага үе таарч байгаа. Усны хэрэгцээ өндөр үед эдгээр худгийн бараг тал хувийг зэрэг ашигладаг ба өдрийн нийт дундаж зарцуулалт 200-835 м³ ус болдог.

Болор ус ХХК, 15-4-29-р байр. 3р баг,
Даланзадгад хот, Өмнөговь аймаг



Болор Ус ХХК болон Ус амьдрал ХХК дээрхи худгуудын ундарга, усны түвшин, ашиглалтын одоогийн байдлыг ашиглагчдаас нь асууж тодруулсан. Эдгээр худгаас №4 Цагаан чулуутын худаг 15 м гүн бөгөөд хилийн боомтын ус хангамжинд хамгийн удаан 20 гаран жил ашиглаж байгаа юм. Гэвч энэ худгийн усны түвшин буураагүй ба хоногтоо 30-40 м³ ус өгсөөр байгаагаас үзэхэд одоогийн ашиглалтын хэмжээ нь усны нөөцөд нөлөөлөхгүй байна.

Эдгээр зүйлийг хамаарах багаар нь ангилж үзэхэд Боршувуутаны багийн шувууд хамгийн их буюу 43% (n=103), Хиазтан 15.4% (n=37), Шонхортон 11.2% (n=27), Галуутан 10.8% (n=26), Өрөвтастан 4.6% (n= 11), Тогоруутан 3.3% (n=8), Тагтаатан 2.09% (n=5), Шунгууртан 1.67% (n=4), Уультан болон Тахиатан тус бүр 1.25% (n=3), Ураацайтан, Хотонтон, Тоншуултан, Зүсэгтэн, Эргүүбортон тус бүр 0.83% (n=2), Өвөөлжтөн, Хөхөөтөн багын шувууд тус бүр 0.41% (n=1) -ийг эзэлж байна.

¹ Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах Оюу толгой төслийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хавсралт 10.6



Зураг 0-1 2016-2021 онд ажиглагдсан шувуудын зүйлийн тоо


Шувуудын талаар явуулж буй хяналт шинжилгээний ажлаар 2021 онд энэ бүс нутгаар нүүдлийн үедээ дайран өнгөрдөг, тохиолдлын ховор тааралддаг, өвөлждөг болон суурин 12 баг, 28 овог, 41 төрөлд хамаарах 75 зүйлийн 18270 бодгаль шувуу тэмдэглэгдэв (9-36). Шувуудын нүүдлийн оргил үе болох 5 дугаар сард 19 зүйлийн 242 бодгаль, 9 дүгээр сард 20 зүйлийн 173 бодгаль тус тус бүртгэгдсэн бол өвлийн 1-2 дугаар саруудад эвэрт болжмор, монгол ногтрууны томоохон сүргүүд ихээр бүртгэгдсэн байна.

Доорх хүснэгтэд Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) шалгуурын дагуу илүү өндөр хамгааллын статустай шувуудыг үзүүлэв (Хүснэгт 1-1).

Хүснэгт 0-1 Оюу Толгой орчимд 2021 онд ажиглагдсан ховор шувууд

Зүйлийн нэр	ШУ-ны нэршил	Бүс нутгийн үнэлгээ	ОУ-ын үнэлгээ	Оршин амьдрах хэлбэр
Нөмрөг тас	<i>Aegypius monachus</i>	АӨ	ХБ	С
Идлэг шонхор	<i>Falco cherrug</i>	УБ	Э	С/ӨЗ
Жороо тоодгой	<i>Chlamydotis macqueenii</i>	Э	Э	ӨЗ

Товчилсон үгийн тайлбар: УБ-устаж болзошгүй, Э-эмээ, АӨ-анхааралд өртөхөөргүй, ХБ- ховордож болзошгүй, ӨЗ-өндөглөн зусдаг, С-Суурин



Зураг 0-2 2021 онд ажиглагдсан шувуудын тоо, зүйлийн баялаг

Хавсралт 10.6

2021 онд ажиглагдсан шувуудыг оршин амьдрах хэлбэрээр нь ангилан үзэхэд өндөглөн зусдаг 15 (20%), нүүдлийн үедээ дайран өнгөрдөг 36 (48%), сүүрин 18 (24%), зусдаг 5 (6.6%), эрмэл 1 (1.3%) зүйл байна.

2021 оны 3 дугаар сард Оюу толгой орчмоор гангар хунгийн томоохон сүргүүд нүүдлийн үедээ дайран өнгөрлөө. Хунгийн сүргүүд уурхайн хашаан доторх зарим уст цэгүүд, Ханбумбат нисэх буудал орчим бүртгэгдсэн.

Хэсгийн дүгнэлт

- 2021 онд Оюу толгой орчимд 75 зүйлийн шувуу бүртгэгдсэн ба тэдгээрийн дийлэнх хувь нь нүүдлийн үедээ дайран өнгөрч буй зүйлүүд байлаа.
- Монгол орны ихэнх газар нутгийг хамран тогтсон цасан бүрхэвч нь тал, хээрийн бүсээр өргөн тархсан зарим зүйл жижиг шувуудад хоол тэжээлийн хомсдол үүсгэх, нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг өдөөгч үндсэн шалтгаануудын нэг юм.

Өвлийн саруудад жижиг шувуудын идэш тэжээлээс хамаарсан тал, хээрийн бүсээс говийг чиглэсэн нүүдэл, шилжилт хөдөлгөөн эрчимждэг. Үүнээс улбаалан 2021 оны 1-3 сард Оюу толгой орчимд шоорон эвэрт болжморын олон бодгаль бүхий том сүргүүд бүртгэгдсэн.



Фото 0-1 Гангар хун (*Cygnus cygnus*)

1.3 Могойч загалайн үүрлэлт, тархалт

1.3.1 Судалгааны зорилго

Оюу Толгой уурхай ховор шувуудад үзүүлэх шууд болон дам нөлөөг тодорхойлох хөтөлбөр боловсруулсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд Оюу Толгой уурхай тус уурхайн орчимд үүрлэж буй могойч загалайн үржлийн төлөв байдлыг үнэлэх, могойч загалайн орон зайн шилжилт хөдөлгөөн, эзэмшил нутгийг тодорхойлох зорилт тавьсан.

1.3.2 Судалгааны арга зүй

Гурван хүний бүрэлдэхүүнтэй баг хээрийн ажлыг 2021 оны 6 сарын 26-аас 7 сарын 12 хүртэл, 2021 оны 8 сарын 4-өөс 8 сарын 8 хүртэл хоёр удаагийн явалтаар нийт 21 хоногт гүйцэтгэсэн. Судалгааны баг Ханбогд сумын орчимд могойч загалай хайх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд шувуу танихад 2 нүдний (10 X 40) болон яндан дуран (25X - 60X) ашигласан.

Могойч загалайд GSM дамжуулагч (Lego 2 by Druid Technology Co., Ltd, China) зүүж орон зайн шилжилт хөдөлгөөний мэдээллийг цуглуулсан.

Могойч загалайн үүр олохын тулд судлаачид Ханбогд, Оюу толгой орчмын голын хөндий дэх хайлаасуудыг бүгдийг сайтар шалгасан. Энэ жил хээрийн судалгааны ажил оройтож эхэлсэн, цаг давчуу байсан учир бид бусад зүйлийн махчин шувуудын бүх үүрийг бүртгээгүй.

Могойч загалай өндөгтэй юмүү нялх ангаахайтай үедээ үүрэндээ байх магадлал өндөр бөгөөд энэ үед үүрийг нь олоход харьцангуй хялбар байдаг. Үүрний амжилт тодорхойлохын тулд могойч загалайн үүр тус бүрийг 2 удаа шалгасан бөгөөд ингэхдээ урт уурганы үзүүрт бэхэлсэн толь болон А-хэлбэрийн шат ашигласан. Бид үүрийг аль болох богино хугацаанд шалгаж шаардлагатай мэдээллээ цуглуулсан даруйд үүрнээс холдож бие гүйцсэн шувууд үүрэндээ ирэх нөхцлийг бүрдүүлсэн.

Үүрэн дээр GPS координат, өндөршил, амьдрах орчны төрөл, модны өндөр, цээжний өндөр дэх модны диаметр, үүрний өндөр гэсэн мэдээллийг цуглуулав. Бие гүйцсэн могойч загалайг mist net болон шар шувууны чихмэл ашиглаж, харин залуу шувууг нисч сурахаас нь өмнө үүрнээс барьж дамжуулагч зүүсэн. Дамжуулагч зүүхийн өмнө шаардлагатай биеийн хэмжээсийг авч метал бөгжөөр бөгжилсөн. Түүнээс гадна үүрэн доторх болон модон доорх хоол тэжээлийн үлдэгдлийн мэдээллийг цуглуулсан.

1.3.2.1 Өгөгдөл боловсруулалт

Тухайн үүрнээс дор хаяж нэг ангаахай амжилттай нисэх юмүү, үүрнээс нисэх хүртэлх хугацааны 80% орчимд хүрэхэд тухайн үүрлэлтийг амжилттай гэж тооцдог (STEENHOF, 1987)². Судлаачид могойч загалайн ангаахайн хөгжлийг 10 долоо хоногт хуваасан зурагт лавлахыг (Mori et al., 2017)³ ашиглаж ангаахайн насыг тодорхойлсон бөгөөд ангаахай 8 долоо хоног болон түүнээс дээш настай болсон тохиолдолд үүрнээс амжилттай ниссэн гэж тооцов. Могойч загалайн apparent nest success-ийг тооцоолов. Хамгийн ойр үүрлэсэн хөрш могойч загалайн үүр хүртэлх зай болон үржлийн тархалтыг GIS програм ашиглан тооцоолов. Эзэмшил нутгийг Минимум конвекс полигон (MCP95%) ашиглан R програм дээр тодорхойлов.

1.4 Судалгааны үр дүн

Судлаачид, 2021 онд могойч загалайн 4 үүр олсон (Зураг 1-3). Могойч загалай хайлаасан дээр дунджаар 4.5±1.2 м өндөрт үүрээ зассан бөгөөд үүрлэж буй модны цээжний өндөр дэх диаметр (DBH) 38.5±13.7 см байлаа.

Оюу толгойгоос урагш 10 км орчимд байрлах үүрний эр, эм шувуудыг 7-р сарын 3 өдөр барьж GSM дамжуулагч зүүсэн. 4830 дугаарын дамжуулагчтай шувуу 7-р сарын 20-оос хойш мэдээ дамжуулаагүй байгаа бол 2021 байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг бичиж байх үед 4829 дугаарын дамжуулагчтай шувуу өдөр бүр мэдээ дамжуулж байгаа бөгөөд


² STEENHOF, K. (1987). ASSESSING RAPTOR REPRODUCTIVE SUCCESS AND PRODUCTIVITY. RAPTOR MANAGEMENT TECHNIQUES MANUAL, 157–170.

³ MORI, D., VYAS, R., & UPADHYAY, K. (2017). BREEDING BIOLOGY OF THE SHORT-TOED SNAKE EAGLE CIRCAETUS GALLICUS. 12(MARCH), 149–156.

Хавсралт 10.6

үржлийн нутагтаа буюу Оюу толгой орчимд байсаар байна.

Хос могойч загалайн эзэмшил нутаг Оюу толгойн уурхайтай яг давхцаж байгаа бөгөөд 4830 дугаарын дамжуулагчтай шувууны эзэмшил нутгийн хэмжээ хэмжээ (MCP95) 1353,9 км², 4829 дугаарын дамжуулагчтай шувууных 2366 км² байна.



Зураг 0-3 Могойч загалайн үүрний байршил болон эзэмшил нутаг

Бид 8-р сард могойч загалайн үүрнүүдийг дахин шалгахад 4 үүрний ангаахайнууд нь 8 болон түүнээс дээш долоо хоногийн настай болсон байсан учир үүрний амжилтыг 100% гэж тооцсон (Хүснэгт 9-15). Түүнээс гадна 3 үүрний ангаахай үүрнээсээ амжилттай ниссэнийг GSM дамжуулагчийн өгсөн мэдээгээр давхар баталгаажуулсан болно.

Хүснэгт 0-2 2013-2017, 2021 онуудад Ханбогд сумын нутагт олдсон могойч загалайн үүрний тоо болон үржлийн амжилт

Огноо	Үүрний тоо	Амжилттай үүрний тоо	Үржлийн амжилт (%)
2013	4	3	0.75
2014	7	5	0.71
2015	8	7	0.88
2016	7	7	1.00
2017	5	4	0.80
2021	4	4	1.00

Хамгийн ойр байрлах хөрш могойч загалайн үүр хүртэлх дундаж зай 47.1±11.5 км, үржлийн тархалтын дундаж зай 2.6±3.3 км байлаа.

Могойч загалайн үүрний 3 км радиус дахь орчин нь ямар нэг байдлаар хүний нөлөөнд өртөөгүй байсан бөгөөд Оюу Толгой уурхайд хамгийн ойрхон үүр нь 13 км зайд байрлах бөгөөд энэ үүр нь Гашуун сухайтын замаас 5 км зайтай байв.

Хэсгийн дүгнэлт

Судлаачид 2021 онд могойч загалайн 4 үүр олсон нь өмнөх жилүүдтэй харьцуулахад үржлийн хосын тоо буурсан. Хэдий тийм боловч бодит байдал дээр үржлийн хосын тоо буурсан гэж шууд дүгнэхэд эрт юм. Энэ жилийн хээрийн судалгааны ажил оройтож эхэлсэн учир бид эрт үүрлээд үүрлэлт нь амжилтгүй болсон зарим тохиолдлуудыг бүртгэж чадаагүй ч байх боломжтой.

Могойч загалайн үүрнүүдийн хоорондын зай грект 2.7 км (Bakaloudis et al., 2005)⁴, Беларуст 6 км (Ivanovsky, 1992)⁵, Италид 4.4 км (Petretti, 1988)⁶, Италийн баруун хойд хэсэгт 13-34 км (Восса, 1989) байсан бол Ханбогд сумын орчмын могойч загалайн үүр хоорондын зай харьцангуй хол буюу 47.1 км байгаа нь Ханбогд сумын орчмын могойч загалайн тоо толгой угаас цөөн байгаатай холбоотой байж болох юм.

Ханбогд сумын орчмын могойч загалайн үржлийн амжилт 2016 оныхтой адилхан 1.0 буюу бусад онуудаас (0.71-0.88) харьцангуй өндөр байв. Харин бусад оронд хийсэн судалгаанд үржлийн амжилт Грект 0.69 & 0.88, Италид 0.75 (Petretti, 1988) байжээ.

Махчин шувууд үржлийн газар нутагтаа сэлгэж ашигладаг 2-3 үүртэй байдаг (Newton, 1979)⁷ бөгөөд үржлийн тархалтын дундаж зай 2.6 км байгаа нь могойч загалай үржлийн газар нутгаа орхилгүй олон жил ашигладаг болохыг харуулж байна.

Бие гүйцсэн шувуудын хувьд 4829 дугаарын дамжуулагчтай бодгаль өдөр бүр мэдээ өгч, одоогийн байдлаар үржлийн нутагтаа байсаар байгаа бөгөөд эзэмшил нутаг нь Оюу толгойтой яг давхцаж байгаа юм. Энэ үүрний могойч загалай Оюу толгой болон Гашуун сухайтын замтай харьцангуй ойрхон байрлаж байгаа ч гэсэн үүрлэлт нь амжилттай болсон нь хүний нөлөөнд харьцангуй бага байсныг харуулж байна.

⁴ BAKALLOUDIS, D. E., VLACHOS, C. G., & HOLLOWAY, G. J. (2005). NEST SPACING AND BREEDING PERFORMANCE IN SHORTTOED EAGLE CIRCAETUS GALLICUS IN NORTHEAST GREECE. BIRD STUDY, 52(3), 330–338.

[HTTPS://DOI.ORG/10.1080/00063650509461407](https://doi.org/10.1080/00063650509461407)

⁵ IVANOVSKY, V. V. (1992). ECOLOGY OF SHORT-TOED EAGLE NESTING IN BYELORUSSIAN POOZERJE. MODERN ORNITHOLOGY, 69–77.

⁶ PETRETTI, F. (1988). NOTES ON THE BEHAVIOUR AND ECOLOGY OF THE SHORT-TOED EAGLE IN ITALY. LE GERFAUT, 78(3), 261–286.

⁷ NEWTON, I. (1979). POPULATION ECOLOGY OF RAPTORS. BUTEO BOOKS.

1 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТАЛААРХ ТОДРУУЛГА

1.1 Хууль, эрхзүйн орчин

1.1.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1994

Энэ хуулиар байгалийн өвөрмөц тогтцыг тусгай хамгаалалтад авах, унаган төрхийг хадгалах, хамгаалах харилцааг зохицуулсан. Тус хуульд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэсэн дөрвөн ангиллаар тусгай хамгаалалттай газар нутгийг ангилсан. Байгалийн нөөц газар нь экологийн нөөц газар, биологийн нөөц газар, палеонтологийн нөөц газар, геологийн нөөц газар, усны нөөц газар гэсэн 5 төрөлд хуваагддаг.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн холбогдох зүйлээс иш татав.

4 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг орчны бүстэй байж болно. Орчны бүсийн эрх зүйн байдлыг тусгай хуулиар зохицуулна.

2. Хуульд өөрөөр заагаагүй бол Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн заагийг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын саналыг харгалзан тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно гэж заасан.

1.1.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, 1995

Энэхүү хуулиар тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийг тогтоох, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар гэж хоёр хэсэгт тусгайлан заажээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн холбогдох зүйлээс иш татав.

3 дугаар зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс

3.1. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ.


9 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

9.1. Орчны бүсэд үйлдвэрийн зориулалтаар мод бэлтгэх, ан агнах, анчдын отог байгуулах, ашигт малтмал эрж хайх, олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах, усан сан байгуулах, далан, хаалт барих зэрэг үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага нь зохих хууль тогтоомжийн дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ.

9.2. Нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэд хамгаалалтын захиргааны санал, дүгнэлтийг тусгана.

1.2 Улсын тусгай хамгаалалттай газар

Доорх зурагт төслийн талбайтай ойролцоо орших улсын тусгай хамгаалалттай газрын байршлыг харуулав. Говийн бага дархан цаазат газрын Б хэсэг Ханбогд салхин цахилгаан станц төслийн талбайн зүүн урд захаас 21.7 км зайтай оршдог.



Зураг 1-1 Улсын Тусгай Хамгаалалттай Газар

Говийн бага дархан цаазат газар Б хэсгийн танилцуулга

Монголын зүүн өмнөд говийн үндсэн хэв шинжийг төлөөлж, байгалийн унаган төрхөө харьцангуй сайн хадгалсан, дэлхийд ховордсон амьтад болох хулан, хар сүүлт, аргаль, янгирын гол байршил нутаг учраас тус газрыг 1996 онд УИХ-ын 43 дугаар тогтоолоор дархан цаазат газар болгожээ. Тус газар нь Өмнөговь аймгийн Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг сумдын нутаг дэвсгэрт нийт 1830429.42 га газар нутгийг хамран оршино.

Тус газарт Монгол орны хулангийн 50 орчим хувь нь энэ нутагт байршин нутагладаг. Байгалийн 2 мужийг төлөөлж Галбын, Борзонгийн говийн өргөн уудам нутгийг хамран байршина. Галбын говийн хэсгээр хотгор дагуудаа бударганат, олон наст бударгана-загт бүлгэмдэлтэй. Талархаг газраа баглуурт, хотгорт мөнгөн хайргат, бор бударганат цөлийн ургамалтай. Мөн хотгор дагуу хужир мараалаг ба элсэрхэг хэсгээр заган ой ихтэй. Хулан, хар сүүлт нь сүүлийн жилүүдэд байгалийн болон хүний үйл ажиллагааны зохисгүй нөлөөний улмаас цөөрөх хандлагатай болсон. Говийн бага ДЦГ нь говийн аймгуудын зааг нутгийг хамрах тул ерөнхийдөө зэлүүд ба хилийн дагуух нутгийг хамгаалах, судлахад чухал ач холбогдолтой. Галбын говийн хэсэг нь Алашаа говийн дэд мужид багтах бөгөөд хотгор дагуудаа бударганат, олон наст бударганат-загт бүлгэмдэлтэй.

ДЦГ-ыг байгалийн хэв шинж, төлөв байдал, хөрс, ус, ургамал, амьтны аймгийн онцлог, хүний үйл ажиллагаанд өртөх байдал зэргийг харгалзан дараах бүсэд хуваадаг. Үүнд:

- Онгон бүс,
- Хамгаалалтын бүс,
- Хязгаарлалтын бүс.

Мөн дархан цаазат газар нь орчны бүстэй бөгөөд тухайн газрын хилийн заагийн гадна оршино. (Зураг 1-1 Улсын тусгай хамгаалалттай газар).

Хавсралт 10.7

Дархан цаазат газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэдэг. Говийн бага дархан цаазат газрын А хэсэг нь 16401.1 км², Б хэсэг нь 10966.9 км² талбай бүхий орчны бүстэй. Ханбогд төслийн талбайн өмнөд хэсэг нь Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн орчны бүстэй хэсэгчлэн давхцдаг (Зураг 1-1).

1.3 Дүгнэлт

Зураг 1-1-ийг харвал төслийн талбай дархан цаазат газартай давхцал байхгүй. Клинтек ХХК-аас БОАЖЯ-нд хүсэлт¹ гаргаж тусгай хамгаалалттай газар нутагтай давхцал байгаа эсэх талаар лавлагаа № 03-4777 авсан ба уг лавлагаанд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжих “Ханбогд салхин цахилгаан станц” төслийн талбай, цахилгаан дамжуулах шугамын трасс болон автозамын трасс бүхий газар нь Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, тус хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 заасны дагуу Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор баталсан Гол мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хилийн зааг, Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор баталсан Усны сан бүхий энгийн хамгаалалтын бүсийн хилийн зааг, Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай тус тус давхцалгүй болохыг баталгаажуулсан болно..

Ханбогд төслийн талбайн өмнөд хэсэг болон нэвтрэх зам Говийн бага дархан цаазат газрын Б хэсгийн орчны бүстэй хэсэгчлэн давхцдаг (Зураг 1-1). Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд орчны бүсэд явагдах үйл ажиллагаанд тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаанаас санал дүгнэлт авч, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх шаардлагуудыг заасан.

Төслийн БОННУ-г боловсруулж, төсөл хэрэгжүүлэгч, БОННУ-ний баг хамтдаа Говийн бага дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргатай 2021 оны 10-р сарын 19, 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр тус бүр 1 удаа буюу нийтдээ **2 удаа** биечлэн уулзаж, санал, дүгнэлтийг мөн **2 удаа** авсан.

Уулзалтын үеэр хүлээн авсан санал, дүгнэлтийг БОННУ-д хавсарган оруулсан болно. Уг саналд Бага говийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйл, 9.1, 9.2 дугаар заалтыг дурдсан бөгөөд тодорхой аж ахуй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд БОННУ хийлгэх шаардлагатай. Түүнчлэн, “Монгол Улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн Орчны Бүсийн тухай” хуульд заасны дагуу төсөл хэрэгжүүлэх явцдаа тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн дэглэмийг баримталж, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль”, “Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай хууль”, Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчны багц хуулийн хүрээнд байгаль орчинд нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах талаар санал өгсөн.

Тиймээс төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн санал, дүгнэлтэд заасан зөвлөмжийг баримтлан, хэрэгжүүлж буй төслийн талаар мэдээлэл хүргүүлж, хамтран ажиллах шаардлагатай.

Иймд, төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны даргын өгсөн зөвлөмжийг даган мөрдөж байгаа бөгөөд төслийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг бэлэн болмогц хүргэж, төслийн нөлөөллийг бууруулахын тулд захиргаатай хамтран ажиллах болно.

¹ БОАЖЯ, 2021.10.12, 03/4777, Хариу хүргүүлэх тухай

Хавсралт 10.8

Ханбогд сумын нутагт 2020-2022 онд ажиглагдсан шувуудын бүртгэл

Энэхүү хавсралтад Ханбогд сумын нутаг дэвсгэрт 2020 оны 9-р сараас 2022 оны 5-р сар хүртэл ажиглагдсан шувуудын зүйлийн жагсаалтыг оруулав.¹ Ажиглалтыг eBird байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн цуврал ажиглалтын үр дүнд буюу мэргэжлийн хүмүүс болон шувуу сонирхогчид сайн дурын үндсэн дээр гүйцэтгэж eBird.org мэдээллийн санд байршуулсан болно. eBird нь тухайн зүйл байгаа эсэх, мөн шувууны элбэг байдлыг шалгах хуудасаар дамжуулан баримтжуулдаг. Вэб интерфэйс нь оролцогчдод өгөгдлийн сангийн интерактив асуулга ашиглан ажиглалтаа оруулах эсвэл үр дүнг харах боломжийг олгодог. Интернет хэрэгслүүд нь шувууны бүртгэлийг хөтөлж, интерактив газрын зураг, график, багана график ашиглан өгөгдлийг дүрслэх боломжийг хэрэглэгчдэд олгодог.

Доор үзүүлсэн мэдээлэл нь Ханбогд сумын нийт нутаг дэвсгэрт хийгдсэн ажиглалтын тоо ба нийт ажиглагдсан зүйл бүр нь Төслийн талбайн хүрээнд хамаарахгүй.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2020 оны 9 сарын 2

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	30	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
2	Эгэл хөхөө	Common Cuckoo	<i>Cuculus canorus</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
3	Шовшуур хөхөө	Oriental Cuckoo	<i>Cuculus optatus</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
4	Эгэл хилэнжигүүр	Black-winged Stilt	<i>Himantopus himantopus</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
5	Бэсрэг тутгалжин	Whimbrel	<i>Numenius phaeopus</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
6	Харцгай	Japanese Sparrowhawk	<i>Accipiter gularis</i>	2	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
7	Сохор элээ	Black Kite (Black-eared)	<i>Milvus migrans</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
8	Талын сар	Long-legged Buzzard	<i>Buteo rufinus</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
9	Хотны бүгээхэй	Little Owl	<i>Athene noctua</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
10	Бөөвөлжин өвөөлж	Eurasian Hoopoe	<i>Upupa epops</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
11	Зээрд шонхор	Lesser Kestrel	<i>Falco naumanni</i>	7	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
12	Начин шонхор	Eurasian Kestrel	<i>Falco tinnunculus</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
13	Амарын шонхор	Amur Falcon	<i>Falco amurensis</i>	4	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
14	Шууман шонхор	Eurasian Hobby	<i>Falco subbuteo</i>	6	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
15	Идлэг шонхор	Saker Falcon	<i>Falco cherrug</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
16	Тольт дунхай	Isabelline Shrike	<i>Lanius isabellinus</i>	2	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
17	Ухаа дунхай	Brown Shrike	<i>Lanius cristatus</i>	2	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
18	Үнсэн дунхай	Great Gray Shrike (Steppe)	<i>Lanius excubitor</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
19	Алаг шаазгай	Eurasian Magpie	<i>Pica pica</i>	5	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
20	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	10	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
21	Шоорон эвэрт болжмор	Horned Lark	<i>Eremophila alpestris</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
22	Монгол жиргэмэл	Mongolian Short-toed Lark	<i>Calandrella dukhunensis</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
23	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02

¹ Ажиглалт S73404688, S88646105, S108791034, S109996833, S110542334, S110550998, S110626563, S110809201, S110809314, S110928821

Хавсралт 10.8

24	Элслэг эргийн хараалай	Bank Swallow	<i>Riparia riparia</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
25	Борлог дууч шувуу	Yellow-browed Warbler	<i>Phylloscopus inornatus</i>	2	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
26	Бүхт дууч шувуу	Dusky Warbler	<i>Phylloscopus fuscatus</i>	20	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
27	Алаг хөөндэй	White's Thrush	<i>Zoothera aurea</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
28	Халиун хөөндэй	Eyebrowed Thrush	<i>Turdus obscurus</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
29	Хурган намнаа	Taiga Flycatcher	<i>Ficedula albicilla</i>	25	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
30	Бүжмч чогчиго	Isabelline Wheatear	<i>Oenanthe isabellina</i>	40	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
31	Цөлийн чогчиго	Desert Wheatear	<i>Oenanthe deserti</i>	5	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
32	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	4	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
33	Шартуруут цэгцгий	Eastern Yellow Wagtail	<i>Motacilla tschutschensis</i>	3	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
34	Шар цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	15	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
35	Хөх цэгцгий	White Wagtail	<i>Motacilla alba</i>	30	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
36	Бөртөт шийхнүүхэй	Olive-backed Pipit	<i>Anthus hodgsoni</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
37	Харзны шийхнүүхэй	Water Pipit	<i>Anthus spinoletta</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02
38	Хүрэнтолгойт хөмрөг	Red-headed Bunting	<i>Emberiza bruniceps</i>	1	Ханбогд, Бага Энгэр Мод	2020.09.02

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2021 оны 5 сарын 21

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Буулгат хүүрзгэнэ	Eurasian Collared-Dove	<i>Streptopelia decaocto</i>	3	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
2	Зээрд хүүрзгэнэ	Red Collared-Dove	<i>Streptopelia tranquebarica</i>	1	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
3	Эгэл хөхөө	Common Cuckoo	<i>Cuculus canorus</i>	1	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
4	Өвөгт тогоруу	Demoiselle Crane	<i>Grus virgo</i>	1	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
5	Согсоот гоорбис	Oriental Honey-buzzard	<i>Pernis ptilorhynchus</i>	3	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
6	Сохор элээ	Black Kite (Black-eared)	<i>Milvus migrans</i>	1	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
7	Өвөөлж	Eurasian Hoopoe	<i>Upupa epops</i>	1	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
8	Амарын шонхор	Amur Falcon	<i>Falco amurensis</i>	2	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
9	Шууман шонхор	Eurasian Hobby	<i>Falco subbuteo</i>	2	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
10	Ухаа дунхай	Brown Shrike	<i>Lanius cristatus</i>	2	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
11	Алаг шаазгай	Eurasian Magpie	<i>Pica pica</i>	7	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
12	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	6	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
13	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	5	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
14	Асрын хараацай	Barn Swallow (Buff-bellied)	<i>Hirundo Rustica</i>	3	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
15	Борлог дууч шувуу	Yellow-browed Warbler	<i>Phylloscopus inornatus</i>	4	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21
16	Жирхэн дууч шувуу	Pallas's Leaf Warbler	<i>Phylloscopus proregulus</i>	7	Ханбогд, Адгийн Сүхайт	2021.05.21

Хавсралт 10.8

17	Бухт дууч шувуу	Dusky Warbler	<i>Phylloscopus fuscatu</i>	18	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
18	Умардын дууч шувуу	Arctic Warbler	<i>Phylloscopus borealis</i>	2	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
19	Халиун хөөндэй	Eyebrowed Thrush	<i>Turdus obscurus</i>	1	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
20	Өнгөлүүрт гургалдай	Siberian Rubythroat	<i>Calliope calliope</i>	2	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
21	Хурган намнаа	Taiga Flycatcher	<i>Ficedula albicilla</i>	12	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
22	Дагуур галсүүлт	Daurian Redstart	<i>Phoenicurus auroreus</i>	6	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
23	Цөлийн чогчиго	Desert Wheatear	<i>Oenanthe deserti</i>	4	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
24	Загийн бор шувуу	Saxaul Sparrow	<i>Passer ammodendri</i>	2	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
25	Хээрийн бор шувуу	Eurasian Tree Sparrow	<i>Passer montanus</i>	15	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
26	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	3	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
27	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail (Gray-backed)	<i>Motacilla citreola citreola/werae</i>	6	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
28		Citrine Wagtail (Black-backed)	<i>Motacilla citreola calcarata</i>	4	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
29	Бөртөт шийхнүүхэй	Olive-backed Pipit	<i>Anthus hodgsoni</i>	3	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
30	Улаавар бужмар	Common Rosefinch	<i>Carpodacus erythrinus</i>	4	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
31	Цагаан хэвэлт хөмрөг	Pallas's Bunting	<i>Emberiza pallasii</i>	2	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21
32	Борлог хөмрөг	Little Bunting	<i>Emberiza pusilla</i>	2	Ханбогд, Адгийн Сухайт	2021.05.21

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 2

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Хондон ангир	Ruddy Shelduck	<i>Tadorna ferruginea</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
2	Ногоохон нугас	Green-winged Teal	<i>Anas crecca</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
3	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	7	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
4	Нарийн хиазат	Little Ringed Plover	<i>Charadrius dubius</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
5	Темминкийн элсэг	Temminck's Stint	<i>Calidris temminckii</i>	4	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
6	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
7	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	20	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
8	Шар цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	3	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
9	Хөх цэгцгий	White Wagtail	<i>Motacilla alba</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02
10	Харзны шийхнүүхэй	Water Pipit	<i>Anthus spinoletta</i>	8	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.02

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 10

#	Зүйлийн нэр	Тоо	Байршил
---	-------------	-----	---------

Хавсралт 10.8

	Монгол	Англи	ШУ-ны			Ажигласан огноо
1	Анхидал ангир	Common Shelduck	<i>Tadorna tadorna</i>	2	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
2	Цагаан хөмсөгт нугас	Garganey	<i>Spatula querquedula</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
3	Зэрлэг нугас	Mallard	<i>Anas platyrhynchos</i>	3	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
4	Ногоохон нугас	Green-winged Teal	<i>Anas creca</i>	16	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
5	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	12	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
6	Зэвэн хиазат	Greater Sand-Plover	<i>Charadrius leschenaultii</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
7	Темминкийн элсэг	Temminck's Stint	<i>Calidris temminckii</i>	45	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
8	Савар элсэг	Long-toed Stint	<i>Calidris subminuta</i>	2	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
9	Эгэл хайргын хөгчүү	Common Sandpiper	<i>Actitis hypoleucos</i>	2	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
10	Сүүлцагаан хөгчүү	Green Sandpiper	<i>Tringa ochropus</i>	6	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
11	Үхэр хөгчүү	Common Greenshank	<i>Tringa nebularia</i>	2	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
12	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
13	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	28	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
14	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
15	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	8	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10
16	Хөх цэгцгий	White Wagtail	<i>Motacilla alba</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.10

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 14

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Хондон ангир	Ruddy Shelduck	<i>Tadorna ferruginea</i>	2	Буйр хөхийн задгай	2022.05.14
2	Бор нугас	Gadwall	<i>Mareca strepera</i>	2	Буйр хөхийн задгай	2022.05.14
3	Эрээнхавирга хахилаг	Chukar	<i>Alectoris chukar</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
4	Бүүлгат хүүрзгэнэ	Eurasian Collared-Dove	<i>Streptopelia decaocto</i>	6	Буйр хөхийн задгай	2022.05.14
5	Нарийн хиазат	Little Ringed Plover	<i>Charadrius dubius</i>	3	Буйр хөхийн задгай	2022.05.14
6	Цармын бүргэд	Golden Eagle	<i>Aquila chrysaetos</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
7	Бөөвөлжин өвөөлж	Eurasian Hoopoe	<i>Upupa epops</i>	3	Буйр хөхийн задгай	2022.05.14
8	Холтсон гоётуул	Eurasian Wryneck	<i>Jynx torquilla</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
9	Зээрд шонхор	Lesser Kestrel	<i>Falco naumanni</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
10	Начин шонхор	Eurasian Kestrel	<i>Falco tinnunculus</i>	2	Буйр хөхийн задгай	2022.05.14
11	Шууман шонхор	Eurasian Hobby	<i>Falco subbuteo</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
12	Алаг шаазгай	Eurasian Magpie	<i>Pica Pica</i>	5	Буйр хөхийн задгай	2022.05.14

Хавсралт 10.8

13	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	3	Буйр хөхийн задгай	2022.05.14
14	Бургасны уран шувуу	White-crowned Penduline-Tit	<i>Remiz coronatus</i>	11	Буйр хөхийн задгай	2022.05.14
15	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	4	Буйр хөхийн задгай	2022.05.14
16	Улаангүеэт хөөндэй	Red-throated Thrush	<i>Turdus ruficollis</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
17	Науманни хөөндэй	Naumann's Thrush	<i>Turdus naumanni</i>	10	Буйр хөхийн задгай	2022.05.14
18	Хүрэн х Науманны хөөндэй (эрлийз)	Dusky х Naumann's Thrush (hybrid)	<i>Turdus eunomus x naumanni</i>	3	Буйр хөхийн задгай	2022.05.14
19	Хурган намнаа	Taiga Flycatcher	<i>Ficedula albicilla</i>	17	Буйр хөхийн задгай	2022.05.14
20	Дагуур галсүүлт	Daurian Redstart	<i>Phoenicurus auroreus</i>	7	Буйр хөхийн задгай	2022.05.14
21	Цөлийн чогчиго	Desert Wheatear	<i>Oenanthe deserti</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
22	Мяраан чогчиго	Pied Wheatear	<i>Oenanthe pleschanka</i>	6	Буйр хөхийн задгай	2022.05.14
23	Хээрийн бор шувуу	Eurasian Tree Sparrow	<i>Passer montanus</i>	10	Буйр хөхийн задгай	2022.05.14
24	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	10	Буйр хөхийн задгай	2022.05.14
25	Бөртөт шийхнүүхэй	Olive-backed Pipit	<i>Anthus hodgsoni</i>	2	Буйр хөхийн задгай	2022.05.14
26	Харзны шийхнүүхэй	Water Pipit	<i>Anthus spinoletta</i>	3	Буйр хөхийн задгай	2022.05.14
27	Цагаан хэвэлт хөмрөг	Pallas's Bunting	<i>Emberiza pallasi</i>	1	Буйр хөхийн задгай	2022.05.14
28	Борлог хөмрөг	Little Bunting	<i>Emberiza pusilla</i>	2	Буйр хөхийн задгай	2022.05.14

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 18

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrhaptes paradoxus</i>	8	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
2	Өвөгт тогоруу	Demoiselle Crane	<i>Grus virgo</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
3	Зэвэн хиазат	Greater Sand-Plover	<i>Charadrius leschenaultii</i>	4	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
4	Тэнгисийн хиазат	Kentish Plover	<i>Charadrius alexandrinus</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
5	Савар элсэг	Long-toed Stint	<i>Calidris subminuta</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
6	Шугуйн хөгчүү	Wood Sandpiper	<i>Tringa glareola</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
7	Сохор элээ	Black Kite (Black-eared)	<i>Milvus migrans</i>	3	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
8	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	3	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
9	Шоорон эвэрт болжмор	Horned Lark	<i>Eremophila alpestris</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
10	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	30	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
11	Асрын алтанхараацай	Barn Swallow (White-bellied)	<i>Hirundo rustica rustica</i>	3	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18

Хавсралт 10.8

12	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
13	Шартуруут цэгцгий	Eastern Yellow Wagtail	<i>Motacilla tschutschensis</i>	2	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
14	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	7	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
15	Хөх цэгцгий	White Wagtail	<i>Motacilla alba</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
16	Цагаан хэвэлт хөмрөг	Pallas's Bunting	<i>Emberiza pallasi</i>	1	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18
17	Борлог хөмрөг	Little Bunting	<i>Emberiza pusilla</i>	3	Оргих худаг, Өмнөговь, (42,987, 107,739)	2022.05.18

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 19

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	46	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
2	Хархираа тогоруу	Common Crane	<i>Grus grus</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
3	Азийн сүвээ цагаан	Black-bellied Plover	<i>Pluvialis squatarola</i>	3	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
4	Зэвэн хиазат	Greater Sand-Plover	<i>Charadrius leschenaultii</i>	10	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
5	Тэнгисийн хиазат	Kentish Plover	<i>Charadrius alexandrinus</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
6	Темминкийн элсэг	Temminck's Stint	<i>Calidris temminckii</i>	9	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
7	Савар элсэг	Long-toed Stint	<i>Calidris subminuta</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
8	Шугуйн хөгчүү	Wood Sandpiper	<i>Tringa glareola</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
9	Шоорон эвэрт болжмор	Horned Lark	<i>Eremophila alpestris</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
10	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	38	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
11	Уулын цэгцгий	Gray Wagtail	<i>Motacilla cinerea</i>	5	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
12	Шартуруут цэгцгий	Eastern Yellow Wagtail	<i>Motacilla tschutschensis</i>	4	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
13	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	13	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19
14	Цагаан хэвэлт хөмрөг	Pallas's Bunting	<i>Emberiza pallasi</i>	3	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.19

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сар 20

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	35	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
2	Өвөгт тогоруу	Demoiselle Crane	<i>Grus virgo</i>	5	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
3	Азийн сүвээцагаан	Pacific Golden-Plover	<i>Pluvialis fulva</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
4	Зэвэн хиазат	Greater Sand-Plover	<i>Charadrius leschenaultii</i>	9	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
5	Темминкийн элсэг	Temminck's Stint	<i>Calidris temminckii</i>	3	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
6	Савар элсэг	Long-toed Stint	<i>Calidris subminuta</i>	3	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20

Хавсралт 10.8

7	Шугуйн хөгчүү	Wood Sandpiper	<i>Tringa glareola</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
8	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	4	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
9	Шоорон эвэрт болжмор	Horned Lark	<i>Eremophila alpestris</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
10	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Aldatala cheleensis</i>	50	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
11	Асрын алтанхараацай	Barn Swallow (White-bellied)	<i>Hirundo rustica rustica</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
12	Бор тодол	White-cheeked Starling	<i>Spodiopsar cineraceus</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
13	Бүжимч чогчиго	Isabelline Wheatear	<i>Oenanthe isabellina</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
14	Шар цэгцхий	Western Yellow Wagtail	<i>Motacilla flava</i>	15	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
15	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	7	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20
16	Хөхтүрүүт хөмрөг	Black-faced Bunting	<i>Emberiza spodocephala/personata</i>	1	Ханбогд, Булаг, 42.98746, 107.74012	2022.05.20

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 21

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Хондон ангир	Ruddy Shelduck	<i>Tadorna ferruginea</i>	4	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
2	Улаанхушуу биваан	Red-crested Pochard	<i>Netta rufina</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
3	Дорнын хүүрэгэнэ	Oriental Turtle-Dove	<i>Streptopelia orientalis</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
4	Бүүлгат хүүрэгэнэ	Eurasian Collared-Dove	<i>Streptopelia decaocto</i>	9	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
5	Соотон гуйванга	Long-eared Owl	<i>Asio otus</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
6	Бөөвөлжин өвөөлж	Eurasian Hoopoe	<i>Upupa epops</i>	2	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
7	Ухаа дунхай	Brown Shrike	<i>Lanius cristatus</i>	7	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
8	Алаг шаазгай	Eurasian Magpie	<i>Pica Pica</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
9	Алагтуу хэрээ	Daurian Jackdaw	<i>Corvus dauuricus</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
10	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	2	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
11	Жирхэн дууч шувуу	Pallas's Leaf Warbler	<i>Phylloscopus proregulus</i>	15	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
12	Бүхт дууч шувуу	Dusky Warbler	<i>Phylloscopus fuscatus</i>	6	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
13	Сибирийн хөөндэй	Siberian Thrush	<i>Geokichla sibirica</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
14	Халиун хөөндэй	Eyebrowed Thrush	<i>Turdus obscurus</i>	5	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
15	Өнгөлүүрт гургалдай	Siberian Rubythroat	<i>Calliope calliope</i>	15	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
16	Дагуур галсүүлт	Daurian Redstart	<i>Phoenicurus aureus</i>	3	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21
17	Алтан жигүүр	Oriental Greenfinch	<i>Chloris sinica</i>	1	Ханбогд, Адгийн сухайт	2022.05.21

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нийт нутагт ажиглагдсан шувуудын бүртгэл, 2022 оны 5 дугаар сарын 21

Хавсралт 10.8

#	Зүйлийн нэр			Тоо	Байршил	Ажигласан огноо
	Монгол	Англи	ШУ-ны			
1	Ногоохон нугас	Green-winged Teal	<i>Anas crecca</i>	3	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
2	Монгол ногтруу	Pallas's Sandgrouse	<i>Syrrhaptes paradoxus</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
3	Азийн сүвээцагаан	Pacific Golden-Plover	<i>Pluvialis fulva</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
4	Зэвэн хиазат	Greater Sand-Plover	<i>Charadrius leschenaultii</i>	24	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
5	Тэнгисийн хиазат	Kentish Plover	<i>Charadrius alexandrinus</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
6	Нарийн хиазат	Little Ringed Plover	<i>Charadrius dubius</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
7	Темминкийн элсэг	Temminck's Stint	<i>Calidris temminckii</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
8	Шугуйн хөгчүү	Wood Sandpiper	<i>Tringa glareola</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
9	Хон хэрээ	Common Raven	<i>Corvus corax</i>	2	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
10	Дэрсний жиргэмэл	Asian Short-toed Lark	<i>Alaudala cheleensis</i>	9	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
11	Согсоот божирго	Crested Lark (Crested)	<i>Galerida cristata</i>	3	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
12	Шартуруут цэгцгий	Eastern Yellow Wagtail	<i>Motacilla tschutschensis</i>	1	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21
13	Шар түрүүт цэгцгий	Citrine Wagtail	<i>Motacilla citreola</i>	17	Оргих худаг, Өмнөговь (42,987, 107,739)	2022.05.21

Эх сурвалж: www.ebird.com